



74

ГОВЬСУМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 31 өдөр

Дугаар 1140

Шивээговь сум

Хаврын эргүүл шалгалт, сурталчилгааны  
ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1, Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Онцгой байдлын ерөнхий газрын 2022 оны Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх тухай” 01 дугаар албан даалгавар, аймгийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн А/74 дүгээр захирамжийг тус тус үндэслэн  
**ЗАХИРАМЖЛАХ НЬ:**

1. Хаврын хуурайшилтын улирал эхэлж, хээрийн түймэр гарах эрсдэлийг өндөрсгөж байгаатай холбогдуулан болзошгүй хээрийн түймэр, байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэдийг мэдлэг мэдээллээр хангах ажлыг эрчимжүүлэх зорилгоор нэгдсэн эргүүл, хяналт шалгалт, сургалт сурталчилгааны ажлыг 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 04 дүгээр сарын 20-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2. Эргүүл, хяналт шалгалт, сургалт сурталчилгааны ажлын удирдамжийг хавсралтаар баталсугай.

3. Эргүүл, хяналт шалгалтыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Т.Өлзийбуд

(Байгаль орчны асуудал хариуцсан  
мэргэжилтэн)

Гишүүд:

Д.Сувд-Эрдэнэ

(1 дүгээр багийн Засаг дарга)

42122-143

С.Отгонбаатар

(2 дугаар багийн Засаг дарга)

Д.Отгонбаатар

(Мал аж ахуйн үйлдвэрлэлийн төлөвлөлт, менежмент, малын үржил, бүртгэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн)


Г.Ууганбаатар

(Цагдаагийн хэсгийн ахлах ахлагч)

Г.Даваажаргал

(Шивээ Овоо хувьцаат компанийн ХАБЭА-н хэлтсийн ахлах инженер)

4. Ажлыг удирдамжийн дагуу чанартай зохион байгуулж, тайлاغнахыг Ажлын хэсгийн ахлагч (Т.Өлзийбуд)-д, малчид, иргэдэд чиглэсэн сурталчилгааны ажлыг эрчимжүүлэхийг (Ажлын хэсэг)-т, сумын Ерөнхий зориулалттай мэргэжлийн ангийн хүн хүч, техник хэрэгслийн бэлэн байдлыг хангаж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ц.Цэрэндорж)-д, захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Ч.Сугармаа)-д тус тус үүрэг болгосугай.



Сумын Засаг даргын 2022 оны 03-р  
сарын 31 ний өдрийн 11:40  
дугаар захирамжийн хавсралт

## ХАВРЫН ЭРГҮҮЛ ШАЛГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ АЖЛЫН УДИРДАМЖ

Нэг. Зорилго

Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 01-ны, өдрийн A/74 дугаар захирамжийн хүрээнд байгаль орчныг хамгаалах, Гамшгаас хамгаалах, ойн тухай хууль тогтоомжуудыг хэрэгжүүлэх болон хаврын хуурайшилтын үе эхэлж байгаатай холбогдуулан сумын хэмжээнд болзошгүй хээрийн түймэр, байгаль орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор эргүүл шалгалтын ажлыг зохион байгуулж ард иргэдийг мэдээ, мэдээллээр хангах, учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх, анхааруулга сэрэмжлүүлэг өгч, ажиллахад оршино.

Хоёр. Хугацаа

Эргүүл хяналт шалгалтын ажлыг 2022 оны 04 дүгээр сарын 01-ны өдрөөс 04 дугаар сарын 20-ны өдрийг дуустал хугацаанд гүйцэтгэх ба хуурайшилтын нөхцөл байдлаас хамаарч уг хугацааг өөрчилж болно.

Гурав. Үйл ажиллагааны чиглэл

Д/Д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа /cap/	Хариуцах байгууллага
Хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд			
1	Ойн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.30-д заасныг хэрэгжүүлэн ой, хээрийн гал түймрийн аюултай үед албан хаагчид, олон нийтийг татан оролцуулах	04.01-04.20	Ажлын хэсэг
2	Эргүүл шалгалтаар илэрсэн хууль бус үйлдлийг шалган хуулийн дагуу арга хэмжээ авч хураагдсан түүхий эдийг журмын дагуу шийдвэрлэх ажлыг зохион байгуулж, олон нийтэд мэдээлэх	Зөрчил илэрсэн тухай бүрд	Ажлын хэсэг
3	Ойн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5-д заасныг хэрэгжүүлэн, хээрийн гал түймрийн цагийн байдлын тухай мэдээг Онцгой байдлын газарт тухай бүр болон хагас жилээр гаргаж өгөх	04.01-04.20	Ажлын хэсэг
4	Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.13-д заасныг хэрэгжүүлэн, хээрийн гал түймэр гарсан		Ажлын хэсэг

	үед бүрэн эрхийнхээ хүрээнд хүн хүч, техник хэрэгслийг дайчлан, гарсан гал түймрийг унтраах ажлыг шуурхай зохион байгуулах		
5	Ойн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, Засгийн газрын 2013 оны 106 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн, хээрийн гал түймрээс учирсан хохирлыг хуулийн хугацаанд тогтоож, тайлагнах		
6	Засгийн газрын 2013 оны 106 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 1.7.1-д заасныг хэрэгжүүлэн хавар, намрын хуурайшилтын улиралд Засаг даргын захирамжаар хуваарь гарган хөдөлгөөнт эргүүл, шалгалт хийх, /Ковид-19/-ын хяналтын постуудыг давхар үүрэгжүүлэн ажиллах		
7	Коронавируст халдварт (COVID-19)-ын цар тахлын тархалттай холбогдуулан мэргэжлийн байгууллагаас гаргасан халдварт хамгааллын дэглэмийг мөрдөж ой, хээрийн гал түймэр унтраахад дайчлах гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сайн дурын хэсгийн Ой, хээрийн гал түймэр унтраах сургалт, дадлагыг зохион байгуулах	04.01-04.20	Ажлын хэсэг
8	Хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээний орон нутгийн хөтөлбөр, төлөвлөгөө, шаардагдах төсвийг батлуулан хэрэгжилтийг хангуулах, биелэлтэд хяналт тавих		
9	Хээрийн гал түймрийн нөхцөл байдал хүндэрч аймаг, нийслэлээс нэмэлт хүн хүч дайчлан ажиллах үед бие бүрэлдэхүүний эрүүл мэндийг хамгаалах зорилгоор харьяа эрүүл мэндийн асуудал хариуцсан байгууллагаас тусгай баг томилон ажиллуулах		

### Дөрөв. Илэрсэн зөрчлийг шийдвэрлэх

Эргүүл шалгалтаар илэрсэн хууль бус үйлдлийг таслан зогсоож холбогдох байгууллагад шилжүүлэн хууль тогтоомж, дүрэм, журмын дагуу шуурхай арга хэмжээ авч ажиллана.

Жич: Тухай бүр маршрут батлуулан эргүүл шалгалтын ажлыг зохион байгуулан тайлагнах.